



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Зон олны нам
(ЗОН)-ын дарга өөрчлөгдсөнийг
бүртгүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Зон олны нам (ЗОН)-ын дарга өөрчлөгдсөнийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Ц.Цогтын илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг.Зон олны намын дарга Э.Одбаяраас: “2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Зон олны намын ээлжит Бага хурал хуралдаанаар Зон олны намын дарга Э.Одбаярын албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг хүлээн авч хэлэлцэж, Бага хурлаар намын даргын Э.Одбаярын хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн бөгөөд Зон олны намын Бага хурлаас намын дүрмийн 18.9.2, 18.9.2, 18.7 дахь хэсэгт заасныг үндэслэн намын даргыг шинээр сонгосон. Иймд шинээр сонгогдсон Зон олны намын даргыг улсын бүртгэлд бүртгэж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулж өгнө үү” гэсэн хүсэлт бүхий өргөдөл гаргаж, өргөдөлдөө:

-Зон олны намын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 2024/01 дүгээр өргөдөл,

-Намын даргын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Бага хурал зарлан хуралдуулах тухай” 2023/С1 дугаар тушаал,

-Намын Удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Бага хурал зарлан хуралдуулах тухай” 2023/У1 дугаар тогтоол,

-Зон олны намын Бага хурлын гишүүдэд хурлын тов мэдэгдсэн 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн мэдэгдэл,

- 2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Бага хурлын 2024/В1, 2024/В2, 2024/В6, 2024/В7 дугаар тогтоолууд,

-Зон олны намын 2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Бага хурлын ирцийн бүртгэл, хурлын тэмдэглэл,

-Флаш (хурлын явцын талаарх дүрс бичлэг)

-Улсын бүртгэлийн гэрчилгээ /эх хувь/

-Улсын тэмдэгтийн хураамж 150,000 төгрөгийг тушаасан баримт болон бусад холбогдох баримтыг хавсарган ирүүлсэн байна.

Хоёр.Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04/256 дугаар албан бичгээр баримт бичгийн бүрдэл хангаж, материал ирүүлэх хугацаа тогтоосны дагуу тус намаас 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баримт бичгийн бүрдэл хангаж, материал хүргүүлэх тухай албан бичиг, намын Бага хурлын гишүүдийн ирцийн бүртгэлийг бичгээр болон тус хурлын явцын бичлэг, Бага хурлын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн БХ-06/02, БХ-06/03 дугаар тогтоол зэргийг бүрдэл хангуулан ирүүлжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр Зон олны нам (ЗОН)-ын дарга өөрчлөгдсөнийг бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна”, 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана”, 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам”, 17 дугаар зүйлийн 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага ... сонгоно” гэж тус тус заасан, энэ тохиолдолд Зон олны нам (ЗОН)-ын Бага хурал буюу төлөөллийн төв байгууллага нь хуралдаж, намын даргыг сонгосон нь дээрх хуулийн зохицуулалт болон тус намын дүрэмд нийцсэн байна.

Зон олны намын удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 2023/У1 дүгээр тогтоолоор намын ээлжит Бага хурлаа 2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр зарлан хуралдуулсан нь тус намын дүрмийн 18.5-т “Намын Бага хурлыг гишүүдийн гуравны хоёр эсвэл Удирдах зөвлөл, намын дарга зарлан хуралдуулж болно” гэж заасантай нийцжээ.

Намын дүрмийн 14.4-т “ЗОН-ын Их хурлын чөлөөт цагт намын төлөөллийн төв байгууллага Бага хурал /БХ/”, 18.9.1-д “Намын Их Хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага болох Бага Хурал шийдвэрлэж болно”, 18.9.2-т “Намын даргыг намын Бага хурлаас нууц санал хураалтаар сонгоно” гэж тус тус заасан буюу Зон олны нам (ЗОН)-ын дүрэмд зааснаар намын даргыг сонгож, өөрчлөх эрх нь намын Бага хуралд олгогдсон байна.

Тус намын Бага хурлын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Бага хурлын гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах” тухай БХ-06/02 дугаар тогтоолоор 22

гишүүнийг нэмж баталж, мөн өдрийн БХ-06/03 дугаар тогтоолоор 12 гишүүнийг чөлөөлж, намын дүрмийн 18.1-д “Намын бага хурал 33-261 гишүүнтэй байна ...” гэж заасантай нийцүүлж Бага хурал нийт 43 гишүүнтэй болжээ.

Өргөдөл гаргагчаас ирүүлсэн баримтаар намын ээлжит Бага хурлын ирц нь дүрмийн 18.7-д “намын Бага хурлын гишүүдийн гуравны хоёроос дээш гишүүн оролцож байгаа бол Бага хурлыг хүчинтэйд тооцно. Бага хуралд оролцогч гишүүдийн олохын саналаар шийдвэр гаргана” гэж заасантай нийцсэн байна.

Зон олны нам (ЗОН)-ын 2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Бага хурлаар намын дарга Э.Одбаярыг өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөнийг баталж, Зон олны намын даргад 3 хүн нэрээ дэвшүүлж, нууц санал хураалтын дүнгээр Б.Цацрал 52.5 хувийн саналаар намын даргаар сонгогдсон болох нь хүсэлтэд хавсаргаж ирүүлсэн баримтаар тогтоогдож байна.

2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Э.Одбаярын өөрийнх нь гаргасан хүсэлтээр намын даргаас нь чөлөөлж, шинээр намын дарга сонгосон нь тухайн намын Бага хурлын эрх хэмжээнд байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан Зон олны нам (ЗОН)-ын Бага хурлын 2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 2024/В7 дугаар тогтоолоор тус намын даргаар Б.Цацрал сонгогдсон тухай өөрчлөлтийг Зон олны нам (ЗОН)-ын улсын бүртгэлийн мэдээлэлд бүртгэсүгэй.

2.Б.Цацралаас Улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг төрийн сангийн 100200700941 тоот данснаас буцаан олгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ